



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2025 оны 10 сарын 10 өдөр

Дугаар 216

Улаанбаатар хот

Сонгон шалгаруулалт зохион байгуулах тухай

Зөвшөөрлийн тухай хуулийн 5.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Радио долгионы тухай хуулийн 5¹ дүгээр зүйлийн 5^{1.1.2}, 5^{1.1.11} дэх заалт, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны А/46 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгт”, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2022 оны 38 тоот тогтоолын хавсралтаар батлагдсан “Хэт богино долгионы радио өргөн нэвтрүүлэгт ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага”-ыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт радио өргөн нэвтрүүлгийн дахин дамжуулах станцад радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт”-ыг 2025 оны 10 дугаар сарын 15-ны өдөр зарлаж, “Сонгон шалгаруулалтын баримт бичиг”-ийг энэхүү тогтоолын хавсралтаар баталсугай.
2. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан сонгон шалгаруулалтыг зохион байгуулах, үнэлгээний ажлын хэсэг байгуулах, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Г.ЧИНЗОРИГ

ГИШҮҮД

Б.АНХБААТАР


Б.БАТЗОРИГ

Ч.ЗОЛБАЯР

А.ЛУВСАН-ОЧИР

А.ҮЙЛСТӨГӨЛДӨР

Харилцаа холбооны зохицуулах хорооны
2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн
216 дугаар тогтоолын хавсралт



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРОО

**ХЭТ БОГИНО ДОЛГИОНЫ РАДИО ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ДАХИН ДАМЖУУЛАХ
СТАНЦАД РАДИО ДАВТАМЖ АШИГЛАХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ СОНГОН
ШАЛГАРУУЛАЛТЫН БАРИМТ БИЧИГ**

№ ХХЗХ-2025 /УБДД-СШ-01/

Улаанбаатар хот
2025 он

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ**СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН УРИЛГА**

Зарласан огноо: 2025 оны 10 дугаар сарын 15-ны өдөр

Сонгон шалгаруулалтын дугаар: ХХЗХ-2025 /УБДД-СШ-01/

Сонгон шалгаруулалтын нэр: Хэт богино долгионы радио өргөн нэвтрүүлгийн дахин дамжуулах станцад радио давтамж ашиглах тусгай зөвшөөрөл олгох

Зөвшөөрлийн тухай хуулийн 5.6 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, Радио долгионы тухай хуулийн 5^{1.1.8}, 5^{1.1.11} дэх заалт, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны А/46 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгт”, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2022 оны 38 дугаар тогтоолоор батлагдсан “Хэт богино долгионы радио өргөн нэвтрүүлэгт ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага”-ыг үндэслэн радио өргөн нэвтрүүлгийн дахин дамжуулах станцад радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтыг зарлаж байна.

Харилцаа холбооны зохицуулах хороо нь дор дурдсан нөхцөлтэйгөөр тусгай зөвшөөрөл эзэмшигчийг сонгон шалгаруулалтад оролцохыг урьж байна.

Оролцох эрх бүхий этгээд	Хамрах хүрээ	Дахин дамжуулах станцад ашиглах радио давтамжийн суваг
Улаанбаатарт арилжааны радиогийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй этгээд оролцоно. Жич: Улаанбаатар хотод дахин дамжуулах станцад радио давтамжийн тусгай зөвшөөрөл авсан этгээд оролцох боломжгүй.	Улаанбаатар	81.3 МГц, 81.7 МГц, 84.9 МГц, 85.3 МГц, 86.1 МГц, 86.5 МГц, 86.9 МГц, 87.3 МГц

Сонгон шалгаруулалтад оролцохыг хүссэн эрх бүхий этгээд сонгон шалгаруулалтын баримт бичгийг Харилцаа холбооны зохицуулах хороонд албан бичгээр хүсэлт гаргаж, цаасан болон цахим хэлбэрээр авах ба зөвхөн нэг сонгон шалгаруулалтын төсөл (цаашид “төсөл” гэх) ирүүлнэ.

Сонгон шалгаруулалтыг 2025 оны 10 дугаар сарын 15-ны өдрөөс 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийг хүртэл зарлаж байна.

Сонгон шалгаруулалтад ирүүлэх төслийг 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 11 цаг 00 минутаас өмнө доорх хаягаар ирүүлнэ үү.

Сонирхсон этгээд сонгон шалгаруулалттай холбоотой бусад мэдээллийг албан бичгээр Зохицуулах хорооны сонгон шалгаруулалтын үнэлгээний ажлын хэсэгт хаяглан ирүүлнэ үү.

Шуудангийн хаяг: **Харилцаа Холбооны Зохицуулах Хороо**
Метро бизнес төв А-блок 5 давхар, Сүхбаатар дүүрэг,
Д.Сүхбаатарын гудамж -13, Улаанбаатар хот
14201-0033, Монгол Улс.
Утас: +976-11-304258, 1800-1858
Цахим хуудас: www.crc.gov.mn
Цахим хаяг: rf-tender@crc.gov.mn

ХОЁРДУГААР БҮЛЭГ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ

А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

2.1 Сонгон шалгаруулалтын цар хүрээ

- 2.1.1 Энэхүү сонгон шалгаруулалтаар Улаанбаатар хотод радио өргөн нэвтрүүлгийн дахин дамжуулах станцад радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрлийн сонгон шалгаруулалтын ажлыг зохион байгуулна.
- 2.1.2 Харилцаа холбооны зохицуулах хорооны 2022 оны 38 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Хэт богино долгионы радио өргөн нэвтрүүлэгт ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага”, тус тогтоолд нэмэлт оруулсан 2023 оны 88 дугаар тогтоол болон энэхүү баримт бичгийг баримтална.

2.2 Эрх бүхий сонгон шалгаруулалтад оролцогч

- 2.2.1. Дараах нөхцлийг бүрэн хангасан хуулийн этгээд сонгон шалгаруулалтад оролцоно. Үүнд:
 - а. Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт арилжааны радиогийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй
 - б. Радио давтамж, радио давтамжийн тусгай зөвшөөрөлтэй.
- 2.2.2. Улаанбаатар хотод радио өргөн нэвтрүүлгийн дахин дамжуулах сувгийн радио давтамж, радио давтамжийн тусгай зөвшөөрөлтэй этгээдийг эрх бүхий бус гэж үзнэ.

Б. СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН БАРИМТ БИЧИГ (СШББ)

2.3 Төслийг бүрдүүлэх, сонгон шалгаруулалтад оролцох

- 2.3.1 Оролцогч нь төслийн иж бүрдлийг энэхүү сонгон шалгаруулалтын баримт бичгийн 2.7-2.13 хүртэл заалтын дагуу бүрдүүлэх ба төслийн иж бүрдлийг маягт №5-д бүртгэж ирүүлнэ.
- 2.3.2 Оролцогч төслийг бэлтгэн ирүүлэхтэй холбогдон гарах бүх зардлыг хариуцах бөгөөд Харилцаа холбооны зохицуулах хороо (цаашид “Зохицуулах хороо” гэх) нь энэхүү зардалтай холбоотой аливаа хариуцлага хүлээхгүй болно.

2.4 Сонгон шалгаруулалтын баримт бичгийг тодруулах

- 2.4.1 Оролцогч нь сонгон шалгаруулалтын баримт бичгийн талаар тодруулга, тайлбар авах шаардлагатай бол хүсэлтээ албан бичгээр Зохицуулах хорооны сонгон шалгаруулалтын үнэлгээний ажлын хэсэгт (цаашид “Үнэлгээний ажлын хэсэг” гэх) гэж хаяглан ирүүлнэ.
- 2.4.2 Үнэлгээний ажлын хэсэг нь төсөл хүлээн авах эцсийн хугацаанаас ажлын **5 (тав)**-аас доошгүй хоногийн өмнө ирүүлсэн тодруулга авах хүсэлтэд хариу өгнө.
- 2.4.3 Үнэлгээний ажлын хэсэг тодруулга өгөх ажлыг зохион байгуулах бөгөөд оролцогчид албан бичгээр мэдэгдэнэ.
- 2.4.4 Үнэлгээний ажлын хэсэг нь сонгон шалгаруулалт зарласнаас хойш ажлын **10-аас** доошгүй хоногийн дараа оролцогчид төсөл бэлдэх зааварчилгааг цахим хэлбэрээр өгнө.

2.5 Сонгон шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах

- 2.5.1 Зохицуулах хороо нь төслийг хүлээн авах эцсийн хугацаа дуусахаас өмнө СШББ-т нэмэлт, өөрчлөлт оруулж болно.
- 2.5.2 СШББ-т оруулсан нэмэлт, өөрчлөлт нь СШББ-ийн салшгүй хэсэг болох бөгөөд түүнийг оролцогчид бичгээр мэдэгдэнэ.

В. СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ТӨСӨЛ БЭЛТГЭХ

2.6 Төслийн ерөнхий болон үнэлгээний нөхцөл, шаардлага

- 2.6.1 Төслийг оролцогчид өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэх ба төсөл нь монгол хэл дээр байна. *(Жич: Зөвхөн техникийн холбогдолтой хавсралт материалууд англи хэл дээр байж болно. Бусад хэл дээрх материалыг монгол хэл дээр баталгаат орчуулгаар орчуулан эх хувийг хавсаргасан байна.)*
- 2.6.2 Радио долгионы тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.6-д заасны дагуу энэхүү баримт бичгийн 2.7-2.13 хүртэл нөхцөл, шаардлагуудыг хангах баримт, материалыг ирүүлнэ.
- 2.6.3 СШББ-ийн 2.8, 2.9, 2.10-т ирүүлсэн төслийн баримт бичгүүд нь радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрлийн гэрээний салшгүй хэсэг болно.

2.7. Төслийн ерөнхий шаардлага

- 2.7.1 Оролцогч нь сонгон шалгаруулалтад оролцох өргөдлийн маягт №1-ийн дагуу албан бичиг;
- 2.7.2 Оролцогч сонгон шалгаруулалтын баримт бичигтэй сайтар танилцаж, холбогдох хууль, захиргааны хэм хэмжээний актуудыг судалсан гэдгээ баталгаажуулсан сонгон шалгаруулалтад оролцогчийн баталгааны маягт №2-ийн дагуу албан бичиг;
- 2.7.3 Байгууллагын бүтэц, удирдлага, үйл ажиллагааны танилцуулга болон радио давтамж ашиглах тусгай зөвшөөрлийн хэрэгцээ шаардлага, төлөвлөж буй үйл ажиллагааны танилцуулга;
- 2.7.4 СШББ-ийн маягт №5-ыг бөглөж хуудасны дугаарыг үнэн зөв тэмдэглэх.

2.8. Радио давтамж ашиглан байгуулах сүлжээ, үйлчилгээний төрөл, түүний хамрах нутаг дэвсгэр

- 2.8.1 Үндсэн сувгийн нэвтрүүлэгч (станц), түүний антен фидерийн тоног төхөөрөмжийн байгуулалтын зураглал, технологи, төхөөрөмжийн ажиллагааны зарчим, блок схем, газар зүйн байршлын мэдээлэл;
- 2.8.2 Дахин дамжуулах нэвтрүүлэгч (станц), түүний антен фидерийн тоног төхөөрөмжийн байгуулалтын зураглал, технологи, төхөөрөмжийн ажиллагааны зарчим, блок схем, газар зүйн байршуулах мэдээллийг маягт №8-ын дагуу бөглөж ирүүлнэ.

2.9. Техник, технологийн сонголт, үзүүлэлт

- 2.9.1 Радио өргөн нэвтрүүлгийн дахин дамжуулах нэвтрүүлэгч, антены техникийн үндсэн үзүүлэлт, тайлбар;
- 2.9.2 Дахин дамжуулах нэвтрүүлэгч болон антены тохирлын гэрчилгээ эсхүл нийлүүлэгчийн мэдэгдэл. *(Үйлдвэрлэгч орны эсвэл үндэсний баталгаажуулалтын байгууллагаас олгосон хүчинтэй гэрчилгээ.)*

2.10. Үйлчилгээ хүргэх хугацааны төлөвлөлт

- 2.10.1 Тоног төхөөрөмжийг суурилуулах төлөвлөлт, хэрэгжүүлэх хугацааг маягт №4-ийн дагуу бөглөж ирүүлнэ.
- 2.11. Өрсөлдөөн, зах зээлд үзүүлэх нөлөө**
- 2.11.1 Тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхлэх бизнес төлөвлөгөө, үр ашгийн талаар танилцуулга.
- 2.12. Санхүүгийн төлөвлөлт, чадавх**
- 2.12.1 Үйлчилгээ хүргэхэд шаардагдах хөрөнгө оруулалт, урсгал зардал, зэргийн тооцсон техник, эдийн засгийн тооцоолол, санхүүгийн төлөвлөлт (*Оролцогч нь хөрөнгө оруулалтыг өөр эх үүсвэрээс санхүүжүүлэх бол хөрөнгө оруулагчийн баталгаа, банкны тодорхойлолт.*);
- 2.12.2 Оролцогчийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан. (*Оролцогч нь энэ заалтын материалыг ирүүлэхгүй бөгөөд үнэлгээний ажлын хэсэг нь Сангийн яамны цахим санхүүгийн тайлангийн системээс авч үнэлгээнд ашиглана.*)
- 2.13. Хүний нөөцийн чадавх**
- 2.13.1 Төслийг хэрэгжүүлэх хүний нөөцийн бодлого, төлөвлөлт, зохион байгуулалт болон удирдлагын баг, инженер техникийн ажилтнуудын талаарх танилцуулга; (*Оролцогч нь энэ хэсэгт материал ирүүлэх шаардлагагүй бөгөөд үнэлгээний ажлын хэсэг нь Зохицуулах хорооны тусгай зөвшөөрлийн сангаас үнэлгээнд авч ашиглана.*)
- 2.13.2 Танилцуулгатай холбоотой хүний нөөцийн мэдээллийг СШББ-ийн маягт №3-ыг бөглөн ирүүлэх.
- 2.14. Тусгай зөвшөөрлөөр эрхлэх үйл ажиллагаанд тавих нөхцөл, шаардлага хангах байдал** (*Оролцогч нь энэ хэсэгт материал ирүүлэх шаардлагагүй бөгөөд үнэлгээний ажлын хэсэг нь Зохицуулах хорооны Радио давтамж, өргөн нэвтрүүлгийн хяналтын төвийн 2025 оны 2-3 дугаар улирлын суурин хяналтын тайланг үнэлгээнд авч ашиглана.*)
- 2.14.1 Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага, гэрээний хэрэгжилтийн байдал.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Г. СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ТӨСӨЛ

- 3.1 Төсөл хүчинтэй байх хугацаа, ирүүлэх хувь**
- 3.1.1 Төсөл нь нээсэн өдрөөс хойш 30 [гуч] хоногийн хугацаанд хүчинтэй байна.
- 3.1.2 Үнэлгээний ажлын хэсэг нь гамшгийн болон онцгой нөхцөл байдлын улмаас төсөл хүчинтэй байх хугацааг сунгахаар шийдвэрлэсэн тохиолдолд оролцогчид мэдэгдэнэ.
- 3.1.3 Оролцогч нь 2.7-2.13-т заасан иж бүрдлийн бичиг баримтын эх хувийг бэлтгэн хавтаслаж, түүнд “ЭХ ХУВЬ” гэсэн бичиглэл хийх ба түүнээс гадна 1 ширхэг “ЦАХИМ ХУВЬ” бэлтгэн ирүүлнэ.
- 3.2 Төслийг битүүмжлэх, бичиглэл хийх**
- 3.2.1 Оролцогч нь төслийн ЭХ ХУВЬ (цаасаар) болон ЦАХИМ ХУВЬ (PDF өргөтгөлтэйгөөр зөөврийн санах ой (USB flash drive эсхүл compact disc)-ийг тус тусад нь “ЭХ ХУВЬ”, “ЦАХИМ ХУВЬ” гэсэн бичиглэл бүхий дугтуйнд хийж битүүмжлэн, урилгад заасан шуудангийн хаягаар үнэлгээний ажлын хэсэгт ирүүлнэ.
- 3.2.2 ЭХ ХУВЬ болон ЦАХИМ ХУВЬ хоорондоо зөрчилдсөн тохиолдолд ЭХ хувийг баримтална.

- 3.2.3 ЭХ ХУВИЙН хуудас тус бүрийг дугаарлаж, тэмдэг дарж баталгаажуулна.
- 3.2.4 Дугтуйнууд дээр дараах тэмдэглэгээ, бичиглэлийг хийнэ. Үүнд:
 - а. Сонгон шалгаруулагч байгууллагын нэр, шуудангийн хаяг;
 - б. Сонгон шалгаруулалтын нэр, дугаар;
 - в. Сонгон шалгаруулалтын төслийг нээх 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 11 цаг 00 минутаас өмнө “НЭЭЖ ҮЛ БОЛНО” гэсэн бичиглэл;
 - г. Сонгон шалгаруулалтад оролцогчийн нэр, шуудангийн хаяг, утас.

3.3 Төсөл хүлээн авах эцсийн хугацаа

- 3.3.1 Төслийг Зохицуулах хорооны шуудангийн хаягаар, төсөл хүлээн авах эцсийн хугацаа 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 11 цаг 00 минутаас хоцроолгүйгээр ирүүлнэ.
- 3.3.2 Төслийг хүлээн авахад Монгол Улсын Стандартчилал, хэмжилзүйн газрын цаг, давтамжийн эталон цагийн серверийн мастер цагийг баримтална.
- 3.3.3 СШББ-ийн 2.5-ийн дагуу СШББ-т нэмэлт, өөрчлөлт оруулсны улмаас төсөл хүлээн авах эцсийн хугацааг сунгасан тохиолдолд үнэлгээний ажлын хэсэг болон оролцогчийн эрх, үүрэг сунгасан хугацааны туршид хэвээр үйлчилнэ.
- 3.3.4 СШББ-т нэмэлт, өөрчлөлт орсон, гамшгийн болон онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд Зохицуулах хороо нь шаардлагатай гэж үзвэл төсөл хүлээн авах эцсийн хугацааг нэг удаа сунгаж болно. Сунгасан тухай мэдэгдлийг оролцогчид албан бичгээр хүргэнэ.

3.4 Хугацаа хоцорсон сонгон шалгаруулалтын төсөл

- 3.4.1 Үнэлгээний ажлын хэсэг нь СШББ-ийн 3.3.1-т заасан төсөл хүлээн авах эцсийн хугацаанаас хойш ирүүлсэн төслийг “хугацаа хоцорсон” гэж зарлан түүнээс татгалзаж, нээлгүйгээр буцаана.

Д. СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ТӨСӨЛ ХҮЛЭЭЖ АВАХ, НЭЭХ

3.5 Төсөл хүлээн авах, нээх үйл ажиллагаа

- 3.5.1 Үнэлгээний ажлын хэсэг нь ирүүлсэн төслийн зөвхөн гаднах битүүмжлэл, бичиглэлийг шалгаж, хүлээн авна.
- 3.5.2 Оролцогчийн ирүүлсэн төсөл нь энэхүү баримт бичгийн 3.2.4 дэх заалтад заасан шаардлагуудыг хангаагүй бол үнэлгээний ажлын хэсэг нь тухайн төслийг хүлээж авахаас татгалзаж, буцаана.
- 3.5.3 Үнэлгээний ажлын хэсэг нь төсөл хүлээж авсан тухайгаа тэмдэглэл хөтөлж, уг төслийг хүлээлгэж өгсөн сонгон шалгаруулалтад оролцогчийн төлөөлөгчид танилцуулан, гарын үсэг зуруулна. (маягт №6).
- 3.5.4 Үнэлгээний ажлын хэсэг нь төслийг хүлээн авах эцсийн хугацаанаас хойш 1 цагийн дотор хүлээн авсан төслийг оролцогчийн төлөөллийг байлцуулан нээнэ. Нээх тодорхой хугацаа, байршлыг оролцогчид төсөл хүлээн авах үед мэдэгдэнэ.
- 3.5.5 Сонгон шалгаруулалтын нээлтэд оролцогчийн төлөөлөгч байлцах эрхтэй ба нээлтэд оролцоогүйгээс үүсэх хариуцлагыг үнэлгээний ажлын хэсэг хүлээхгүй.

- 3.5.6 Үнэлгээний ажлын хэсэг нь сонгон шалгаруулалтын нээлт дээр төсөл ирүүлсэн оролцогчийн нэрийг зарлаж, тэмдэглэл үйлдэн, оролцогчоор гарын үсэг зуруулна. (маягт №7).
- 3.5.7 Үнэлгээний ажлын хэсэг нь төслийг үнэлэх хүртэл хүлээн авсан төслийн материалыг бүрэн бүтэн хадгална.

Е. СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ТӨСЛИЙГ ҮНЭЛЭХ

3.6 Үнэлгээний ажлын хэсэг

- 3.6.1 Үнэлгээний ажлын хэсэг нь ахлагч, нарийн бичиг, гишүүдээс бүрдсэн 5-оос доошгүй сондгой тооны бүрэлдэхүүнтэй байх бөгөөд Зохицуулах хорооны даргын тушаалаар байгуулна.
- 3.6.2 Үнэлгээний ажлын хэсэг нь ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүссэн гэж ойлгогдохуйц нөхцөл байдал үүссэн тохиолдолд ашиг сонирхлын мэдэгдэл болон нууцын баталгааг тус тус гарган ажиллана.
- 3.6.3 Үнэлгээний ажлын хэсэг нь сонгон шалгаруулалтын үнэлгээ, дүгнэлтийг Зохицуулах хорооны хуралд танилцуулж, шийдвэрлүүлнэ.
- 3.6.4 Хэрэв үнэлгээний ажлын хэсгийн ахлагч, нарийн бичиг, гишүүн нь оролцогчтой ашиг сонирхлын зөрчил үүснэ гэж үзвэл үнэлгээний ажлын хэсэгт ажиллахаас татгалзаж болно.

3.7 Төслийг хянан үзэх, шаардлагад нийцсэн эсэхийг тогтоох

- 3.7.1 Үнэлгээний ажлын хэсэг нь эрх бүхий оролцогчийн төслийг нарийвчлан үнэлэхээс өмнө төслийн иж бүрдлийг хангасан эсэхийг СШББ-ийн маягт №5-ын дагуу хянан үзнэ.
- 3.7.2 СШББ-ийн маягт №5-д заасан иж бүрдлийг бүрэн хангаж байгаа, түүнд заасан баримт бичиг, нотлох баримт болон бусад маягтуудыг зохих ёсоор ирүүлсэн, маягтуудын агуулгад өөрчлөлт оруулаагүй төслийг ШААРДЛАГАД НИЙЦСЭН төсөл гэнэ.
- 3.7.3 Үнэлгээний ажлын хэсэг нь СШББ-ийн 3.7.2-т зааснаас бусад төслийг ШААРДЛАГАД НИЙЦЭЭГҮЙ гэж үзэж, уг төслийг нарийвчилсан үнэлгээнд оруулахаас татгалзана.
- 3.7.4 Үнэлгээний ажлын хэсэг нь зөвхөн СШББ-ийн 3.7.2-д заасан ШААРДЛАГАД НИЙЦСЭН гэж хянан үзсэн төслийг СШББ-ийн 3.8.1-д заасны дагуу үнэлнэ.

3.8 Төслийг үнэлэх

3.8.1 Үнэлгээний ажлын хэсэг нь дараах үзүүлэлтүүдийн дагуу үнэлнэ. Үүнд:

№	СШББ-т тодорхойлсон нөхцөл, шаардлагууд	Үнэлгээний оноо
1	Радио давтамж ашиглан байгуулах сүлжээ, үйлчилгээний төрөл, түүний хамрах нутаг дэвсгэр	15 хүртэл
2	Техник, технологийн сонголт, үзүүлэлт	35 хүртэл
3	Үйлчилгээ хүргэх хугацааны төлөвлөлт	10 хүртэл
4	Өрсөлдөөн, зах зээлд үзүүлэх нөлөө	5 хүртэл
5	Санхүүгийн төлөвлөлт, чадавх	15 хүртэл
6	Хүний нөөцийн чадавх	10 хүртэл
7	Тусгай зөвшөөрлөөр эрхлэх үйл ажиллагаанд тавих нөхцөл, шаардлага хангасан байдал	10 хүртэл
Нийт үнэлгээний оноо		100 оноо

- 3.8.2 Үнэлгээний ажлын хэсэг нь төслийн нөхцөл, шаардлага тус бүрээр үнэлгээний ажлын хэсгийн гишүүдийн өгсөн онооны дундажийг нэмж, нийт оноог гаргана.
- 3.8.3 Авбал зохих 100 онооны 70 ба түүнээс дээш оноог аваагүй тохиолдолд тухайн сонгон шалгаруулалтын төслийг тэнцээгүйд тооцно.
- 3.8.4 Сонгон шалгаруулалтын үнэлгээ, дүгнэлтэд үнэлгээний ажлын хэсгийн бүх гишүүд гарын үсэг зурж баталгаажуулах бөгөөд эсрэг саналтай гишүүн дүгнэлтэд энэ тухайгаа тэмдэглүүлж гарын үсэг зурна.
- 3.8.5 Үнэлгээний ажлын хэсэг нь шалгарсан оролцогчдыг авсан хамгийн өндөр онооноос эхлэн эрэмбэлж, жагсаалт гаргана.
- 3.8.6 Сонгон шалгаруулалтын оноо тэнцсэн тохиолдолд Харилцаа холбооны зохицуулах хорооны Радио давтамж, өргөн нэвтрүүлгийн хяналтын төвийн 2025 оны суурин хяналтын тайланд үндэслэн шийдвэрлэнэ.
- 3.8.7 Үнэлгээний ажлын хэсэг сонгон шалгаруулалтын нэгдсэн үнэлгээ, жагсаалт болон дүгнэлтийг Зохицуулах хорооны хуралдаанд танилцуулж, шийдвэрлүүлнэ.

3.9 Радио давтамж, радио давтамжийн зурвасыг сонгуулах

- 3.9.1 Зохицуулах хороо үнэлгээний ажлын хэсгийн нэгдсэн үнэлгээ, жагсаалт, дүгнэлтийг хэлэлцэж, шалгарсан оролцогчдод радио давтамжийн зурвас сонгуулах тухай шийдвэрийг гаргана.
- 3.9.2 Үнэлгээний ажлын хэсэг нь оролцогчдод шалгарсан эсэх талаарх мэдэгдлийг албан бичгээр хүргэнэ.
- 3.9.3 Үнэлгээний ажлын хэсэг нь СШББ-ийн 3.9.1-ийн шийдвэрийн дагуу хамгийн өндөр оноо авсан оролцогчоос эхлэн радио давтамж (81.3 МГц, 81.7 МГц,

84.9 МГц, 85.3 МГц, 86.1 МГц, 86.5 МГц, 86.9 МГц, 87.3 МГц)-ийн сувгуудыг сонгуулж, баталгаажуулна.(маягт №9)

- 3.9.4 Оролцогч нь радио давтамжийн зурвасыг сонгуулах үйл ажиллагаанд оролцоогүй тохиолдолд жагсаалтын дараагийн оролцогчоор радио давтамжийн сувгуудаас сонгуулна.
- 3.9.5 Үнэлгээний ажлын хэсэг нь шалгарсан оролцогчийн сонгосон радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрөл олгох дүгнэлтийг оролцогч тус бүрээр Зохицуулах хорооны хуралдаанд танилцуулж, шийдвэрлүүлнэ.

3.10 Үнэлгээний ажлын хэсэгтэй харилцах

- 3.10.1 Талууд сонгон шалгаруулалттай холбоотой аливаа асуудлаар үнэлгээний ажлын хэсэгтэй төслийг нээхээс гэрээ байгуулах эрх олгох хүртэлх хугацаанд зөвхөн бичгээр харилцана.
- 3.10.2 Төслийг үнэлэх, гэрээ байгуулах эрх олгох тухай шийдвэр гаргах явцад оролцогчоос үнэлгээний ажлын хэсэгт нөлөө үзүүлэх аливаа оролдлого нь тухайн оролцогчоос ирүүлсэн төслөөс татгалзах үндэслэл болно.

3.11 Гомдол гаргах

- 3.11.1 Оролцогч нь сонгон шалгаруулалтын мэдэгдэл хүлээн авснаас хойш ажлын **5 [тав]** хоногийн дотор бичгээр гомдол гаргаж болно.

3.12 Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдал

- 3.12.1 Гамшгийн онц нөхцөл байдал зарласан, гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдал үүссэн үед Зохицуулах хороо зохих шийдвэрийг гаргаж, оролцогчид албан бичгээр мэдэгдэнэ.

МАЯГТУУД

МАЯГТ №1

СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАД ОРОЛЦОХ ӨРГӨДЛИЙН МАЯГТ

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРООНД

.... он ... сар ... өдөр

Сонгон шалгаруулалтад оролцох тухай

Бид /сонгон шалгаруулалтад оролцогчийн нэр/, ХХЗХ-2025/УБДД-СШ-01/ дугаартай “ХЭТ БОГИНО ДОЛГИОНЫ РАДИО ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ДАХИН ДАМЖУУЛАХ СТАНЦАД РАДИО ДАВТАМЖ АШИГЛАХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ”-д оролцох хүсэлтэй байна.

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга : _____

Албан тушаал, нэр:

Хаяг: _____

МАЯГТ №2

СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАД ОРОЛЦОГЧИЙН БАТАЛГААНЫ МАЯГТ

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРООНД

.... он ... сар ... өдөр

Энэхүү сонгон шалгаруулалтын баримт бичигт заасан Харилцаа холбооны тухай, Радио долгионы тухай, Өргөн нэвтрүүлгийн тухай, Зөвшөөрлийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт, тухайн үйлчилгээнд хамаарах тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын дагуу саналаа үнэн зөв бүрдүүлсэн болно.

Сонгон шалгаруулалтын төслийг боловсруулахдаа тухайн үйлчилгээ эрхлэхтэй холбоотой үүрэг, үйлчилгээний зах зээл, онцлогийг харгалзан үзэж холбогдох захиргааны хэм хэмжээний актууд, нөхцөл, шаардлагуудыг судалсан бөгөөд энэхүү сонгон шалгаруулалтын баримт бичиг, түүний бүх хавсралтыг бүрэн хүлээн авч, сайтар танилцсан болно.

Бүрдүүлсэн баримт бичигт худал, ташаа мэдээлэл орсон бол хуулийн хариуцлагыг бид хүлээхээ үүгээр баталгаа гаргаж байна.

Сонгон шалгаруулалтад оролцогчийн нэр: _____

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга : _____

Албан тушаал, нэр: _____

Хаяг: _____

МАЯГТ №3

ТУХАЙН АЖЛЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ШААРДАГДАХ АЖИЛЛАХ ХҮЧНИЙ
МЭДЭЭЛЛИЙН МАЯГТ

№	Ажиллах ажилтны овог, нэр	Албан тушаал	Ажилласан жил		Төгссөн их дээд сургууль, дипломын дугаар
			Тухайн байгууллагад	Мэргэжлээрээ	
1					
2					
3					
4					
5					
...					

Жич: Төгссөн их дээд сургууль, дипломын хуулбар хавсаргахгүй.

МАЯГТ №4

ДАХИН ДАМЖУУЛАХ СТАНЦ СУУРИЛУУЛЖ, НЭВТРҮҮЛЭХ ХУГАЦААНЫ
ХУВААРИЙН МАЯГТ

Хэрэгжүүлэх ажлууд	Хугацаа /сар, өдөр/				
	сар	сар	сар	сар	сар

МАЯГТ №5
ИЖ БҮРДЛИЙН МАЯГТ

Энэхүү баримт бичгийн холбогдох заалт	Төслийн иж бүрдэл	Шаардлага хангасан болон материалыг бүрдүүлсэн бол ✓ тэмдэглэгээ хийнэ	Хуудасны дугаар
2.7.1	Оролцогч нь сонгон шалгаруулалтад оролцох өргөдлийн маягт №1-ийн дагуу албан бичиг		
2.7.2	Оролцогч сонгон шалгаруулалтын баримт бичигтэй сайтар танилцаж, холбогдох хууль, захиргааны хэм хэмжээний актуудыг судалсан гэдгээ баталгаажуулсан сонгон шалгаруулалтад оролцогчийн баталгааны маягт №2-ын дагуу албан бичиг		
2.7.3	Байгууллагын бүтэц, удирдлага, үйл ажиллагааны танилцуулга болон радио давтамж ашиглах тусгай зөвшөөрлийн хэрэгцээ шаардлага, төлөвлөж буй үйл ажиллагааны танилцуулга		
2.8.1	Радио төхөөрөмжийн байгуулалтын зураглал, технологи, төхөөрөмжийн ажиллагааны зарчим, блок схем		
2.8.2	Радио өргөн нэвтрүүлгийн дахин дамжуулах станцын газар зүйн байршиллын мэдээллийг маягт №8-ын дагуу бөглөж ирүүлнэ		
2.9.1	Радио өргөн нэвтрүүлгийн дахин дамжуулах нэвтрүүлэгч, антены техникийн үндсэн үзүүлэлт, тайлбар		
2.9.2	Нэвтрүүлэгч болон антены тохирлын гэрчилгээ эсхүл нийлүүлэгчийн мэдэгдэл		
2.10.1	Тоног төхөөрөмж Улаанбаатар хотод суурилуулах төлөвлөлт, хэрэгжүүлэх хугацааг маягт №4-ийн дагуу бөглөж ирүүлнэ		
2.11.1	Тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхлэх бизнес төлөвлөгөө		
2.12.1	Үйлчилгээ хүргэхэд шаардагдах хөрөнгө оруулалт, урсгал зардал, зэргийн тооцсон техник, эдийн засгийн тооцоолол, санхүүгийн төлөвлөлт		
2.13.2	Танилцуулгатай холбоотой хүний нөөцийн мэдээллийг СШББ-ийн маягт №3-ыг бөглөн ирүүлэх		

МАЯГТ №6

СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ТӨСӨЛ ХҮЛЭЭН АВСАН ТУХАЙ ТЭМДЭГЛЭЛИЙН
МАЯГТ

Сонгон шалгаруулалтын нэр:	Хэт богино долгионы радио өргөн нэвтрүүлгийн дахин дамжуулах станцад радио давтамж ашиглах тусгай зөвшөөрөл олгох
Сонгон шалгаруулалтын дугаар:	№ ХХЗХ-2025/ УБДД-СШ-01/

Сонгон шалгаруулалтад оролцогч хуулийн этгээдийн нэр:	
Сонгон шалгаруулалтын төсөл ирүүлсэн огноо, хугацаа:	
Сонгон шалгаруулалтын төсөл хүлээлгэн өгсөн хүний нэр, албан тушаал:	
Холбоо барих утас:	
Баталгаажуулалт: /гарын үсэг /	

Сонгон шалгаруулалтын төсөл хүлээн авсан хүний нэр, албан тушаал:	
Хүлээн авсан огноо, хугацаа:	

МАЯГТ №7

СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН НЭЭЛТИЙН ТЭМДЭГЛЭЛИЙН МАЯГТ

Сонгон шалгаруулалтын нэр:	Хэт богино долгионы радио өргөн нэвтрүүлгийн дахин дамжуулах станцад радио давтамж ашиглах тусгай зөвшөөрөл олгох
Сонгон шалгаруулалтын дугаар:	№ ХХЗХ-2025/ УБДД-СШ-01/

Сонгон шалгаруулалтыг хүлээн авах эцсийн хугацаанд буюу 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 11 цаг 00 минутаас өмнө ирүүлсэн сонгон шалгаруулалтын материалуудыг мөн өдрийн 12 цаг 00 минутаас өмнө нээж, дор дурдсан мэдээллийг зарлаж тэмдэглэв.

№	Сонгон шалгаруулалтад оролцогчийн нэр	Төслийн бичиглэл	Төслийн битүүмжлэл	Нээлтэд оролцсон хүний нэр, албан тушаал	Гарын үсэг
1					
2					
...					

МАЯГТ №8

РАДИО ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ДАХИН ДАМЖУУЛАХ СТАНЦЫН ГАЗАР ЗҮЙН
БАЙРШЛЫН МЭДЭЭЛЛИЙН МАЯГТ

РАДИО ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД РАДИО ДАВТАМЖ, РАДИО ДАВТАМЖИЙН
ЗУРВАС АШИГЛАХ ДАХИН ДАМЖУУЛАХ СТАНЦ

САНАМЖ:

- ✚ Радио нэвтрүүлэгч станцын байршлын мэдээллийг Google Earth программ ашиглан координатыг "decimal degrees" /DDD.DDDDD/ форматаар үнэн зөв бөглөнө.

НЭВТРҮҮЛЭГЧИЙН МЭДЭЭЛЭЛ / INFORMATION OF TRANSMITTER

Хаяг	Нэвтрүүлэгчийн загвар	Антену загвар	Байршил	
			Уртлаг / Longitude / E	Өргөрөг / Latitude / N

МАЯГТ №9

РАДИО ДАВТАМЖИЙН СУВГИЙГ СОНГОЖ БАТАЛГААЖУУЛАХ МАЯГТ

Асуумж:	Бөглөх хэсэг:
Огноо:	Он ____ сар ____ өдөр ____
Зөвшөөрөл хүсэгчийн нэр:	
Регистрийн дугаар:	
Сонгон шалгаруулалтын дүнг хүлээн зөвшөөрсөн эсэх:	☐ Тийм ☐ Үгүй
Сонгосон суваг /МГц/:	
Тавигдах шаардлага:	Үндсэн сувгийн тусгай зөвшөөрөл хүчингүй болсон тохиолдолд энэхүү дахин дамжуулах станцын зурвасын тусгай зөвшөөрөл нь хүчингүй болно. Энэхүү радио давтамжийг зөвхөн Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт 88-108 МГц зурваст ажиллаж буй радио өргөн нэвтрүүлгийг дахин дамжуулах зорилгоор ашиглана. Зөвшөөрөл эзэмшигч нь дахин дамжуулах станцыг дангаар ажиллуулахыг хориглоно.
Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдийн овог нэр:	
Албан тушаалын нэр:	
Холбоо барих утас:	
Гарын үсэг:	

---oOo---